



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/465

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Ханбүргэд Номин” ХХК (4189507) эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг (Хэрлэн), Тэмүүжин Ж-01 тоотод байрлах төрийн захиргааны байгууллагын зориулалттай 2870 м² газраас 183 м² газрыг Худалдаа үйлчилгээний төв цогцолбор “Ханбүргэд хаан хоёр” ХХК-д (4207092) 38 жилийн хугацаатайгаар хэсэгчлэн шилжүүлж 2687 м² үлдэнэ эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн цахим гэрчилгээг олгон гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг “Ханбүргэд номин” ХХК-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 20-ны А/530 дугаар захирамжийн 1 хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



۶۵۸ ۲۰ ۷

بهره و بهر کلام بقصد

[illegible]